

## ДЭД БҮЛЭГ. ГАЗРЫН ЗУРАГ

---

### ЭРТНИЙ БОЛОН ДУНДАТ ЭРТНИЙ МОНГОЛ ГҮРНИЙ НУТАГ ДЭВСГЭР, ГАЗАРЗҮЙН БИЕТҮҮДИЙН НЭР ДЭЛХИЙН БОЛОН БҮС НУТГИЙН ГАЗРЫН ЗУРАГТ ТУССАН ТОЙМООС

Э. Равдан

**Товч агуулга:** *Үүний тухай өгүүлэхийн учир нь эл асуудал монгол судлалд тэр бүр тавигдаагүй, эхлэл төдий байгаад оршино. Тэр нь дэлхийн хийгээд Монголын түүх, соёл, хүн судлал, газарзүй, оноосон нэрзүй зэрэг цөөнгүй сав ухаанд хамаатай тул олон талаас нь авч үзүүштэй, томоохон цар хүрээ бүхий цогцолбор судалгаа шаардах асуудал бөлгөө. Тэр бүгдийг нэг далайцаар шийдэх нь бүү хэл, тоймлох боломжгүй гэдгийг миний бие гүнээ ухаарч уг цогцод эртний, дундад эртний дэлхийн хийгээд Өрнийн болон Төв, Зүүн өмнөт Азийн газрын зургуудад монгол газарзүйн биетүүдийн нэр туссан талаас нь тус МУИС-ийн Нэр судлалын төвд сүүлийн 10 жил хуримтлагдсан баримт сэлтэд тулгуурлан өгүүлэхийг хичээв.*

Хүмүүн төрөлтний түүхэнд талын монгол нүүдэлчид Ази, Европын олон улс гүрнийг хоёр ч удаа дайлан авч дэлхийн өв түүх, соёлд маргашгүй, мартагдашгүй ул мөрөө үлдээн мөнхөрсөн бөлгөө. Тэрхүү үйлийг түүхэн цаг хугацааны ангиллаар нь *эртний, дундад эртний* хэмээн зааглан үзэж зарим баримт сөхөн доор өгүүлсү.

Эртний Их Монгол гүрний нутаг дэвсгэр гол төлөв түүхэн сурвалж бичгүүдийн баримтанд тулгуурлан хожим бүтээсэн дэлхийн болон бүс нутгийн газрын зургуудад туссан байна. Тэдгээрийн нэг нь Дэлхий түүхийн газрын зургийн цомогт (World History Chart) багтсан зураг болой. Эл зурагт эртний үедээ Төв Ази, өнөөгийн Хятадын умард хэсэг буюу Жоу Жаны<sup>1</sup> нутаглаж байсан Алтайн өвөг хэлтэн, тэр дундаа монгол, түрэг хэл аялгуутай<sup>2</sup> хүннүчүүд м.о.т. 350-аад оны үед Европт нэвтэрсэн бол арай хожим, Баян

<sup>1</sup> Түүхч Г. Сүхбаатарын нотолгоогоор Жоу Жаны (Жужань), Аваар хоёр нь угтаа нэг нэр бөгөөд утга нь “нуруу” ажээ. Г. Сүхбаатар, Монгол Нирун улс, УБ., 1992 –ээс үзнэ үү.

<sup>2</sup> Эл үеийн түүхэн сурвалжуудыг судалсан эрдэмтдийн саналаас үзвэл аваар, хүннү нар монгол, түрэг хоёр хэлтэй байсан гэж үзэх төлөвтэй байна. Тухайлбал, Пеллио, Лигети нарын хувьд тэд нь монгол хэлтэн байсан гэсэн бол: Pelliot P., Notes on Marco Polo, Paris, 1959, Notes sur l’histoire de la Horde d’Or. 2326 note., Lajos Ligeti, *A magyar nyelv török kapcsolatai és ami körülöttünk van.* o, Budapest, 1977 pp- 307, sqq. түрэг судлаач, Мажаарын зарим эрдэмтэн түрэг хэлтэн байсан хэмээн нотлох аястай ажээ. Түүний нотолгоо нь: János Harmata, Gönül Yılmaz нарын (De La Question Concernant La Langue Des Avars, Inscriptions Runiques Turques En Europe Orientale (Ankara, 1988) нарын бүтээл болно. Гэхдээ юутай ч гэсэн тэдний тулгуур болгосон эх бичгийн сурвалж болон эд өлгийн зүйлд дээрх хоёр хэлний баримт зэрэгцэн хэрэглэгдэж байгаа нь чухал юм. Тодруулбал, Гилиа

Э.Равдан

МУИС-ийн Гадаад хэл, соёлын сургууль  
ravdan2000@yahoo.com



**Фүтаки Хироши, Камимүра Акира, Э.Равдан, Л.Чулуунбаатар**

*Монгол орны газрын зураг болон газар нутгийн нэрийн судалгааны асуудлууд*  
МУИС пресс хэвлэлийн газар, Улаанбаатар, 2012, ISBN 978-99962-72-59-2

хааны Аваарын их эзэнт гүрэн 552 онд Европыг дайлан цаад тал нь 568 онд Византийн нутаг дэвсгэрээс таслан авч Италийн хойд, баруун хэсэгтэй нэгтгэн их гүрнээ өргөтгөж явжээ. Хожимдоо 626 онд Константинополь руу довтолж яваад анхны том ялагдал хүлээсэн байна. Тэд түүнээс хожуухан дотоодын зөрчил, гадны шахалтаар слав олон овог аймгийнхан Балканыг орхихын хамт баруун этгээд дэх эрх мэдлээ бага багаар алдсаар Газрын дундад тэнгис, Каспийн тэнгисийн эхэнд Хазаар гүрэнд нэгдэж, хожим X зууны үеэс одоогийн Унгар буюу Мажаарын нутаг, Бессераб, Кавказын нуруу, Ижил мөрний ай сав зэрэг газраар таран нутагшжээ. Тиймээс дээрх бүс нутагт тархсан (монгол газар нутгийн нэр нь МГНН) нь дундад эртний үеэс өмнөх үеийн байхыг үгүйсгэх аргагүй.




Аваарын эх нутгийг харуулсан өөр нэг зураг ч таарч байна.




Дэлхийн хамгийн эртний газрын зурагт тооцдог 10 зургийн нэг болох м.о.т. II зууны үед бүтээсэн Ромын Птолемийн (Claudius Ptolemaeus) газрын зурагт эртний Хүннү, Аваарын гүрний хэсэг туссан байж болох юм. Учир нь уг зураг олон жижиг хэсэг болсон хэлбэрээр олдсон бөгөөд хожим нь XIII зууны үед Птолемийн газарзүй (Ptolemy's Geography) бүтээлийг иш үндэс болгон XV зуунд засч сэлбэн гаргасан 27 эртний газрын зурагт Их монгол гүрний хил хязгаарыг Grand Tartary (Tartaia)<sup>3</sup> нэрээр Ижил мөрнөөс Далай хүртэл эсвэл Библийн II бүлэгт гардаг Гихон голоос Шивэр хүртэлх өргөн уудам нутгийг эзлэн оршдог хэмээн хэмээн тэмдэглэснийг Baddeley Jonh T. (1919), Molchanova O.<sup>4</sup> зэрэг цөөнгүй судлаач заасан байна. Уг зургийг засч сэлбэсэн байдлаар нь доор харуулав.

Немет 1930-аад оны үед эртний аваар, хүннүчүүдийн бичгийн сурвалжаас үүдэн: (Voir Gyula Németh, *A honfoglalala magyarsag kialakulsa*. Budapest 1930, pp. 103, sqq.) цол хэргэм заасан нэр : *qayan, qatun, tarqan, tudun, uyuruš*, хүний нэр: *Bayan, Qamsavči, Kók, Solaq* зэрэг баримтыг дурдсан бол Харамата, Елмаз нар Аваарын үеийн Жаношидын 228 –р булшнаас гарсан зүүний хавтагийн дөрвөн талын бичээсийг тайлж уншсан дөрвөн өгүүлбэрт эдүгээгийн түрэг хэлэнд байгаа үгээс гадна “эгч” гэсэн монгол үг байгаа нь анхаарал татахаар байна.

<sup>3</sup> Өрнөдийн Эртний дэлхийн болон Дундад эртний газрын зурагт энэхүү нэрээр Монгол гүрний хил хязгаарыг тэмдэглэжээ.  
<sup>4</sup> Baddeley Jonh T. (1919) *The Whole* by Jonh T. Baddeley . In Two vol. L., Macmillan and Company, Limited, St. Martin's Street, Molchanova O. *The Territory of Southern Siberia and Its peoples on the Medieval Maps* (Эл товхимолоос үзнэ үү.)



Нэн эртний Монголын түүхтэй холбон энд 1179 онд зохиогдсон Ци-дань-го-цзн түүхэнд орсон Кидан гүрний зургийг тэмдэглэж болох юм.



Эл зурагт эдүгээ гаргагдаж байгаа цөөн нэрийг бид д-р М. Чимэдцэеэгийн орчуулгаар доор жагсаав. Үүнд: 佛 Бурхан уул, 北海 Хойд далай, 上京 Дээд нийслэл, 新上京 Шинэ Дээд нийслэл, 长白山 Урт Цагаан уул (Одоогийн Солонгост бий), 王府 Хааны ордон, 北海 Вейхай, 北平 Хойд тэгш, 北岳 Хойд толгод, 南京 Нанжин (Өмнөд нийслэл) болно. Бусад нэрийг зургаас унших боломжгүй байв. “Кидан” нэрийн түүхэн гаргалгааг П.Пеллио-гийн “Catai”<sup>5</sup> өгүүллээс үзэж болно. Тэрбээр уг нэр өнөөдрийн бидний “хятад”-нэрийн язгуур болохыг хөдөлбөргүй нотолжээ. Түүнээс улбаалан өрнийн зарим хэлэнд, тухайлбал орос хэлэнд “китай” нэр Дундад Азийн хэл аялгуугаар дамжин оржээ.

Дундад эртний үеийн Монгол их гүрний хил хязгаар Өрнө, Дорнын хийгээд дэлхийн газрын олон газрын зурагт туссан нь ойлгомжтой. Бид тэр бүгдийг тоочин тоймлох боломжгүй тул бид доор Дундад эртний үед Өрнийн цөөнгүй оронд *Tartary*, *Tartaia*, *Tartaroum*, *Mogul* нэрээр зориуд үйлдсэн Их Монгол гүрний газрын зургуудаас танилцуулая. Гэхдээ энэ удаа уг зургуудыг судалгааны эргэлтэнд оруулах үүднээс зөвхөн ерөнхий танилцуулгыг нь өгч тэдгээрт туссан мэдээллийг бид орхив. Зураг бүрийг нарийвчлан судлах үйл нь хожмын хэрэг хэмээн үзсэн болно. Үүнд:

### 1. Нэр нь: ORTELIUS, A. - *Tartariae sive magni Chami regni typus*.

**Хэвлэгдсэн нь:** Бельгийн Антверпт, 1590 онд

**Хэмжээ нь:** 13.8 x 18.5 inch буюу 35.0 x 47.1 см.

Өнгөөр ялгасан, Калифорни тэмдэглэгдсэн хэсэгт нэг жижиг хүрэн толбо бий. Зурагт Хятад, Япон туссан боловч Солонгос харагдахгүй байна. Хятад, Япон хоёрын дунд Хятад тэнгисийг MARE CIN хэмээн нэрлэсэн хэд хэдэн арал байна. Зурагт 1275, 1291 онд Марк Пологийн аялалтай холбоотой газрын зураг бөлгөө. Энэ тухай хожмын мэдээллийг Японд 1540 оны үед байсан Португалийн католик шашны төлөөлөгч өгсөн байна.

### 2. Нэр нь: MAGINI, G.A. - *Tartariae Imperium*.

**Хэвлэгдсэн нь:** Германы Кологне хотод, 1590 онд

**Хэмжээ нь:** 4.9 x 6.7 буюу 12.5 x 17.0 см.

Өнгөөр ялгаагүй.

Уг зургийг Германы дөрөв дэх том хот Кологнед Petrus Keschedt хэмээгч хүмүүн үйлдсэн

<sup>5</sup> Pelliot P. Notes on Marco Polo, Paris, 1959, pt 1, 536. Уг өгүүлэл монгол хөрвүүлгээр бидний эрхлэн бэлдсэн “Дэлхийд тархсан монгол газар нутгийн нэр” (УБ., 2006, 83-110 талд бий.) товхимолд бий.

байна. Зурагт Монгол, Япон, Калифорни тусчээ. Энэ нь 1570 онд Abraham Ortelius-ын үйлдсэн зургийн багасгасан хувилбар юм. Туссан мэдээлэл нь бага. Японыг *IAPA* гэж тэмдэглэжээ.

### **3. Нэр нь: MERCATOR, G. / HONDIUS, J. - Tartaria.**

**Хэвлэгдсэн нь:** Амстердам, 1608 онд

**Хэмжээ нь:** 5.5 x 7.3 inch буюу 14.0 x 18.6 см.

Өнгөөр ялгасан.

Зурагт өнөөгийн Монголоос гадна Хятад, Солонгос, Америкийн Номхон далайн хойд эрэг нэлээн тод тусчээ. Хоёр тив Анианы хоолойгоор заагласан нь харагдаж байна. Эл зураг анх Jodocus Hondius франц бичвэрийг хянан тохиолдуулсан Atlas Minor-т анх орж хэвлэгдсэн байна. Atlas Minor нь хэмжээгээрээ тухайн түүхэн үед гарсан зургийн бусад цомогуудыг бодвол том тул газрын биетүүд оноосон нэрээрээ туссан нь тэмдэглүүштэй.

### **4. Нэр нь: LANGENES, B. - Tartaria.**

**Хэвлэгдсэн нь:** Амстердам, 1609 онд

**Хэмжээ нь:** 3.3 x 4.7 inch буюу 8.4 x 12.0 см.

Өнгөөр ялгаагүй.

Уг зурагт Монголоос гадна Хятад, Солонгос, Орос улсын хил хязгаар тусчээ. Зургийн нэрийг зүүн дээд өнцөгт нь заасан байна. Анх 1598 онд Амстердамын Petrus Kaerius, Jodocus Hondius I нэрт урчууд оролцон эл жижиг газрын зургийг бүтээсэн байна. Тэр нь Европын орнуудад гарсан газрын зургийн цомгуудад шинэ загвар болсон түүхтэй ажээ.

### **5. Нэр нь: SPEED, J. / HUMBLE, J. - A newe mare of Tartary.**

**Хэвлэгдсэн нь:** Лондон, 1627 онд

**Хэмжээ нь:** 15.2 x 19.9 inch буюу 38.5 x 50.5 см.

Өнгөөр ялгасан, төв хэсгийн доод талд нь жижиг толбыг засаж арилгасан.

Эл газрын зураг нь Өрнөдийн орнуудад Дундад эртний үед гарсан Монгол гүрний цөөнгүй газрын зургаас өвөрмөц чимэглэлээрээ гойд ялгаатай. Астрахани, Самарканд, Камбул зэрэг хотуудын хүн амын хувцас хунар, бусад чимгийг дээд хэсэгт нь байрлуулжээ. Хятадын Цагаан хэрэм тод харагдаж байна. Баруун доод өнцөгт нь Солонгосын хэсгийг “Corea Ins” арлын нэрээр тусгажээ. Түүнчлэн Ар Солонгосын нийслэл “Taixem” нэрээр туссан нь тэмдэглүүштэй.

### **6. Нэр нь: BLAEU, W. - Tartaria sive Magni Chami imperium.**

**Хэвлэгдсэн нь:** Амстердам, 1638 онд

**Хэмжээ нь:** 15.0 x 19.8 inch буюу 38.2 x 50.2 см.

Өнгөөр ялгасан, хатуу цаасан дээр үйлдсэн, франц тайлбартай.

Зурагт Монгол болон Хятад, Солонгосын умард зурвас хэсэг туссан байна. Хятад Цагаан хэрмийг тод дүрсэлжээ. Төв Азийг Монгол болон Хятад дахь Хубилай хааны зуны ордон Xanadu-гаас аваад Каспийн тэнгис, Ижил мөрөн, нөгөө талдаа Түвд, Ганга мөрний дээд хэсэг хүртэл хэсгээр харуулсан байна. Зургийг тэмээ хөтөлсөн хүний дүрсээр чимэглэсэн байна. Эл зургийг 1638 онд Willem Blaeu-г нас барсны дараа нь хүү Joan нь франц тайлбар бүхий “Le Theatre du Monde ou Nouvel Atlas” газрын зургийн цомогийн II ботид хэвлүүлсэн байна.

### **7. Нэр нь: OLEARIUS, A. - Tarku Urbs Tartaroum in Dagestan ad mare Caspium.**

**Хэвлэгдсэн нь:** Парист, 1656 онд

**Хэмжээ нь:** 8.0 x 9.6 inch буюу 20.3 x 24.3 см.

Өнгөөр ялгасан, нэмгэн цаасан дээр үйлдсэн, франц тайлбартай.

Зурагт Дагестаны Тарки хотын эртний төрх байдлыг дүрсэлжээ. Зургийг XVII зууны Германы эрдэмтэн Adam Olearius Перс, Орос зэрэг улсад Элчин сайдын ажилтан, элчин сайд зэргээр ажиллаж байхдаа дээрх орнуудын газар нутгийг судлан энэхүү зургийг бүтээжээ.

**8. Нэр нь: DE WIT, F. - Tabula Tartariae et majoris partis regni Chinae.**

**Хэвлэгдсэн нь:** Амстердам, 1680 онд

**Хэмжээ нь:** 17.2 x 21.7 inch буюу 43.6 x 55.0 см.

Өнгөөр ялгасан, цаас нь бага зэрэг шарласан.

Зурагт Каспийн тэнгисээс Тайваны арлууд хүртэлх орон зайг багтаажээ. Түүнчлэн Солонгос, Япон, Камчаткийн өмнөд эрэг харагдаж байна. Уул, мод зэргийг сайтар дүрсэлсэн байна.

**9. Нэр нь: ALLARD, C. - Tartaria, sive magni Chami Imperium ex credendis amplissimi viri Nicolai Witsen.**

**Хэвлэгдсэн нь:** Амстердам, 1705 онд

**Хэмжээ нь:** 19.7 x 23.2 inch буюу 50.0 x 59.0 см.

Өнгөөр ялгасан.

Уг зурагт Орос улс, түүний Шивэрийн хэсэг, Юань буюу Хөх гүрний Хятадын хэсэг нэлээн тод туссан тул мэдээллийн баян сантай. Томоохон 6 хуудас бүхий эл зургийг Nicolas Witsen 1687 бүтээсэн нь Европын олон нийт Умард Азийг ухаарч олгоход ихээхэн тус дэм болжээ. Nicolas Witsen 24 наснаасаа Орос улсаар аялаж эхлээд бараг 28 жилийн дараа Дундад эртний Монгол гүрний алдарт Noord en Oost Tartaryen газрын зургаа хэвлүүлсэн байна. Эл газрын зургийн тухай судлаач Johannes Keuning “Nicolaas Witsen as a Cartographer” (Imago Mundi, Vol. XI, pp. 95-110) бүтээлдээ: “Ном шиг энэ зураг утгазохиолын нэн ховор эртний бүтээлийн нэг мөн” гэж тодорхойлсон байна.

**10. Нэр нь: DE L'ISLE, G./ RENARD, L. - Carte de Tartarie.**

**Хэвлэгдсэн нь:** Амстердам, 1706 онд

**Хэмжээ нь:** 19.0 x 25.1 inch буюу 48.2 x 63.8 см.

Өнгөөр ялгасан, зургийн дээд хэсэг хуучирч элэгдсэн.

Эл газрын зургийг Амстердамын нэр нь үл мэдэгдэх зураач бүтээжээ. Зурагт Төв Ази, Түвд, Солонгос, Японы *Terre d'Eso* нэгэн арлын хэсэг багтаж оржээ.

**11. Нэр нь: DE L'ISLE, G. - Carte de Tartarie.**

**Хэвлэгдсэн нь:** Парист, 1706 онд

**Хэмжээ нь:** 19.0 x 25.0 inch буюу 48.3 x 63.4 см.

Өнгөөр ялгасан, цаас нь хуучирч харалсан.

Зургийн эх “Chez l'Auteur Rue des Canettes ргйз de St. Sulpice” нь нэн ховор газрын зурагт багтдаг. Зургийн тайлбар “Rue des Canettes”-г эхийг нь 1700-1707 онд бүтээсэн гэж тэмдэглэжээ. Зурагт Зүүн өмнөт Ази, Солонгос, Японы Хоккайдо арлын нэг хэсэг *Terre d'Eso* нэрээр туссан байна.

**12. Нэр нь: PETRINI, P. - La Gran Tartaria descritta secondo le relationi .**

**Хэвлэгдсэн нь:** Умард Италийн Напелст, 1717 онд

**Хэмжээ нь:** 19.5 x 22.7 inch буюу 49.5 x 57.7 см.

Өнгөөр ялгаагүй, доод хэсгийг нь засч янзалсан.

Эл газрын зургийг De Fer бүтээжээ. Зурагт Солонгос, Япон багтсан байна. Зурагт Монгол их гүрний гадна талд *Yuri* хагас арал харагдаж байна. Тэр нь Хоншу арлаас *Zungar* (Tsugaru) хоолойгоор тусгаарлагдсан байна.

**13. Нэр нь: D'ANVILLE, J. B. - Xe feuille de la Tartarie Chinoise, contenant le Païs de KE-TCHING, l'embouchure du SAGHALIEN-OULA dans la Mer orientale.**

**Хэвлэгдсэн нь:** Хаагт, 1737 онд

**Хэмжээ нь:** 11.5 x 22.5 inch буюу 29.2 x 57.2 см.

Өнгөөр ялгаагүй.

Эл газрын зургийг Jean Baptiste Bourguignon d'Anville (1697-1782) бүтээжээ. Тэр нь “Nouvel atlas de la Chine, de la Tartarie chinoise et du Thibet : contenant les cartes générales & particulieres de ces pays, ainsi que la Carte du Royaume de Corée ...” газрын зурагт цомогт багтсан тухайн

хязгаар нутгийг нарийвчлан харуулсан эртний нэгэн зураг болой. Дундад эртний Монгол гүрний хил хязгаарт Хятад, Түвдийг багтаан уг цомогийг католик шашны төлөөлөгчдийн мэдээлэлд тулгуурлан J. B. d'Anville бүтээжээ. Зурагт Ар Шивэрийн нутаг дэвсгэр тусчээ. Түүнд хот суурин, гол мөрөн, уул, гудамж талбайг дүрсээр тэмдэглэжээ.

#### **14. Нэр нь: ALBRIZZI, G. B. - Tartaria.**

**Хэвлэгдсэн нь:** Италийн Венисед, 1740 онд

**Хэмжээ нь:** 10.8 x 13.3 inch буюу 27.5 x 33.8см.

Өнгөөр ялгасан, өргөн хуудаастай.

Энэ бол Солонгос, Японыг багтаасан Шивэрийн сайн зургийн нэг юм. Зураг Венисед Guillaume De L'Isle бүтээлд тулгуурлан бүтээсэн “*Atlante Novissimo Che Contiene Tutte Le Parti Del Mondo...*” газрын зургийн цомогт хэвлэгдсэн байна. Эл газрын зургийг Isaak Tirion-ы бүтээлийг иш үндэс болгон бүтээжээ. Эл зурагт Камчаткийг Умард Японы хэсэг болгон “Kiriliski” нэрээр тэмдэглэсэн нэн сонирхолтой. Харин Хоккайдо арал тусаагүй байна. Куриллийн арлуудыг Японы нутаг дэвсгэрт багтаан дүрсэлсэн байна.

#### **15. Нэр нь: Tartary China Russia**

**Хэвлэгдсэн нь:** Парист, 1683 онд

**Цаасны хэмжээ нь:** с. 5 1/4” W x 8 1/8” H.

Өнгөөр ялгасан.

Зурагт өнөөгийн Монгол, Орос, Хятадын хэсэг тусчээ. Зургийг Mallet бүтээж хожим XVII зууны үед чимэглэлийг үйлджээ. Гар аргаар хийсэн тул өвөрмөц өнгөөр ялгажээ. Мэдээллийн сонин агуулгатай.

#### **16. Нэр нь: COVENS, J. / MORTIER, C. - Carte de Tartarie Dressée sur les Relations de plusieurs Voyageurs.**

**Хэвлэгдсэн нь:** Амстердам, 1745 онд

**Хэмжээ нь:** 19.4 x 24.2 inch буюу 49.4 x 61.5 см.

Өнгөөр ялгасан, цаас нь шарласан.

Зурагт Их Монголын гүрний хил хязгаарыг нэлээн нарийвчилан харуулжээ. Чимэглэлийг нь зэс оролцуулан үйлдсэн байна. Түүнд өнөөгийн Орос улсын Шивэр, Умард Хятад, Солонгос туссан байна. Эл газрын зургийн тайлбарыг Голландын De L'Isle үйлдсэн байна. Түүнийг Covens, J. Mortier, C нар *Atlas Nouveau, Contenant Toutes Les Parties Du Monde, Ou sont exactement Remarquées les Empires, Monarchies, Royaumes, Etats, Républiques &c. Par Guillaume de l'Isle. Premier Géographe de sa Majesté* газрын зургийн цомогт хэвлүүлсэн байна.

#### **17. Нэр нь: HARREVELT, E. van/ CHANGUION, D.J. - Carte de la Tartarie Occidentale.**

**Хэвлэгдсэн нь:** Амстердам, 1749 онд

**Хэмжээ нь:** 8.5 x 6.0 inch буюу 21.5 x 15.3 см.

Өнгөөр ялгасан, сайн хадгалагдсан.

Нэр нь үл мэдэгдэх урлаачийн бүтээл. Уг газрын зурагт хойд талдаа Байгаль нуураас эхлэн ургашаа Бээжин болон Хятадын төв хэсэг, зүүн талдаа Шар тэнгис хүртэлх өргөн уудам орон зай багтжээ. Түүндэн Орос, Хятад, Монголын хил хязгаар нутаг, Монголын өмнөт хэсэг буюу говийн бүс нэлээн тод тусчээ. Олон уул, гол мөрөн, нуур зэргийн тоон үзүүлэлтийг милиэр илэрхийлжээ. Зургийг цэцэг навч, эвхмэл хээгээр чимэглэсэн байна. Зургийг бүтээхдээ De La Harpe's Voyages болон бусад Англи газрын зургийн мэдээллийг ацшиглажээ. Зураг *Atlas Portatif pour servir a l'intelligence de l'Histoire Philosophique et Politique des établissements et du commerce des Européens dans les deux Indes* цомогт хэвлэгдсэн байна.

#### **18. Нэр нь: TIRION, I. - Nieuwe kaart van Tartarie.**

**Хэвлэгдсэн нь:** Амстердам, 1750 онд

**Хэмжээ нь:** 11.0 x 13.5 inch буюу 28.0 x 34.3 см.  
Өнгөөр ялгасан, сайн хадгалагдсан, өргөн хуудастай.  
Зурагт Монгол, Солонгос, Японы хэсэг тусчээ.

**19. Нэр нь: HARREVELT, E.van / CHANGUION, D.J. - Carte de La Tartarie Orientale.**

**Хэвлэгдсэн нь:** Амстердам, 1773 онд  
**Хэмжээ нь:** 9.3 x 13.1 inch буюу 23.5 x 33.2 см.  
Өнгөөр ялгасан, сайн хадгалагдсан.  
Зурагт Дундад эртний Монгол гүрний нэлээн дэлгэрэнгүй ховор зургийн нэг болой. Зурагт Сахалины арал туссан байна. Анх *Atlas Portatif pour servir a l'intelligence de l'Histoire Philosophique et Politique des etablissements et du commerce des Européens dans les deux Indes* газрын зургийн цомогт хэвлэгдсэн байна. Зургийг 709-1711 оны хооронд католик шашны төлөөлөгчдийн ирүүлж байсан мэдээлэл, зарим англи эх сурвалжийг иш үндэс болгон бэлтгэжээ.

**20. Нэр нь: LOTTER. T. - Carte géographique contenant le royaume de Sibérie .**

**Хэвлэгдсэн нь:** Германы Аусбүргт, 1770-1780 онд  
**Хэмжээ нь:** 19.3 x 42.7 inch буюу 49.0 x 108.4 см.  
Өнгөөр ялгасан, 2 хуудастай, хуудас нь 490x1084 мм хэмжээтэй.  
Зурагт Их Монгол гүрний Шивэрийн өнөөгийн ОХУ-ын Тобольск, Енисейск, Эрхүүгийн муж хэсгийг маш нарийвчлан харуулсан нэн ховор зураг. Зургийн баруун дээд хэсэгт Чукотскийн хагас арал 4 x 8 см хэмжээтэй туссан байна. Зураг 1 : 13,000,000 масштабтай. Түүнийг Albrecht Lotter 1741 чимэглэжээ. Эл газрын зургийг 1770 оны орчим Ivan Fomic Truscot (1721-1786, comp. ВМС ХХII, 353) хэвлүүлжээ. Хожим нь цөөнгүй хэвлэгдсэн байна.

**21. Нэр нь: MONDHARE / NOLIN, J.B. - Carte Générale de l'Empire des Russes et de la Tartarie Universelle.**

**Хэвлэгдсэн нь:** Парист, 1783 онд  
**Хэмжээ нь:** 8.2 x 10.1 inch буюу 20.8 x 25.6 см.  
Өнгөөр ялгасан.  
Дундад эртний Монгол, Орос, Солонгос, Японы хил хязгаарыг сайтар харуулсан нэн ховор газрын зураг. Түүнийг J.B.Nolin бэлдээд Monhare *Atlas Général a l'usage des colleges et maisons d'éducation* газрын зургийн цомогт хэвлүүлсэн байна. Хожим нь Францад нэг биш удаа хэвлэгдсэн байна.

**22. Нэр нь: ZATTA, A. - La Tartaria Chinese.**

**Хэвлэгдсэн нь:** Венист, 1784 онд  
**Хэмжээ нь:** 2.1 x 15.8 inch буюу 30.8 x 40.1см.  
Өнгөөр ялгасан.  
Зурагт Их Монгол гүрний Хятадын зүүн хойд хэсгийг тусгажээ. Түүний хамт Солонгосын нутаг дэвсгэр нэлээн нарийвчлалтай багтсан байна. Хоккайдо арлыг зурагт *Jeso-Gasima* гэж нэрлэсэн нь тэмдэглүүштэй. Зургийг G.Pitteri чимэглэжээ.

**23. Нэр нь: DESNOS / BRION - Grande Tartarie et Isles du Japon Suivant les relations les plus authentiques.**

**Хэвлэгдсэн нь:** Парист, 1790 онд  
**Хэмжээ нь:** 11.1 x 18.9 inch буюу 28.3 x 48.0 см.  
Өнгөөр ялгасан.  
Зурагт Орос, Азийн умард хэсэг, Хятад, Түвд, Түрэгстан, Япон улс туссан байна. Зургийн хоёр талд газарзүйн мэдээллийг францаар бичиж байрлуулжээ. Бичвэрт Солонгосыг тухайлан: "La Corée, presque isle qui tient a la Tartarie Chinoise, forme un Royaume qui, depuis plusieurs siecles, est tributaire de l'Empire de la Chine: c'est *Kingkitao* qui est la ville capitale, &

le résidence du Roi.” өгүүлсэн байна. “Kinkitao” гэж өнөөгийн БНСУ-ын нийслэлийг нэрлэн “Li” (Kiang) голын эргээр байрлуулжээ. Зургийг Louis Brion de la Tour бэлдэн Louis Charles Desnos *Atlas Général et Élémentaire pour l'Etude de la Géographie et de l'Histoire modern* газрын зургийн цомогт хэвлүүлсэн байна.

**24. Нэр нь: CASSINI, G. - La Parte Orientale della Russia Asiatica Delineata Sulle Ultime Osservazioni?**

**Хэвлэгдсэн нь:** Ромд, 1796 онд

**Хэмжээ нь:** 13.3 x 18.5 inch буюу 33.9 x 47.0 см.

Өнгөөр ялгасан, цаас нь шарласан.

Нэр нь үл мэдэх хүний бүтээсэн Их Монгол гүрний энэхүү зурагт Берингийн хоолой, Алеутын арлуудыг багтаасан Баруун Аляскийн хэсэг багтжээ. Гэхдээ нарийвчилсан мэдээлэл байхгүй байна. Ром хотноо Presso la Calcografia Camerale хэвлэлийн газар 1796 онд хэвлэгджээ.

**25. Нэр нь: BORGHI, A.B. - La Siberia o sia Russia Asiatica e la Tartaria Chinesa .**

**Хэвлэгдсэн нь:** Флоренсед, 1818 онд

**Хэмжээ нь:** 9.1 x 12.0 inch буюу 23.0 x 30.5 см.

Өнгөөр ялгасан, цагаан цаасан дээр хэвлэсэн.

Бүс нутгийн нэн ховор газрын зураг. Зурагт өнөөгийн Монгол, Түвд, Солонгос, ОХУ-ын томоохон хэсэг багтжээ. Камчаткаас Уралын нуруу хүртэлх газар нутгийг харуулсан байна. Зургийг нэрт газарзүйч Bartolomeo Borghi (1750-1821) Florentine-н цомогт хэвлүүлжээ.

**26. Нэр нь: WALKER, J. / C. / ARROWSMITH, J. - Siberia and Chinese Tartary.**

**Хэвлэгдсэн нь:** Лондонд, 1838 онд

**Хэмжээ нь:** 12.5 x 15.2 inch буюу 31.8 x 38.5 см.

Өнгөөр ялгасан.

Гангаар хүрээлэн урласан. Өнөөгийн Монгол, Манжуур, ОХУ-ын Шивэр, Солонгос, Японы хэсэг багтжээ. Зургийг Society for the Diffusion of Useful Knowledge нийгэмлэгээс эрхлэн 1838 оны 6-р сарын 15 нд хэвлэн гаргажээ.

**27. Нэр нь: SDUK - Eastern Siberia.**

**Хэвлэгдсэн нь:** Лондонд, 1864 онд

**Хэмжээ нь:** 13.0 x 15.4 inch буюу 33.0 x 39.0 см.

Өнгөөр ялгасан.

Камкаткийн хагас арлыг оруулсан Шивэрийн газрын зураг. Газрын гадаргууг өвөрмөц байдлаар харуулсан байна. Түүнийг Piadischev, Lutke олон бусад судлаачийн эх сурвалжид тулгуурлан бүтээжээ. Зургийн чимгийг С. Walker гүйцэтгэж “The Society for the Diffusion of Useful Knowledge” нийгэмлэгээс эрхлэн хэвлүүлжээ.

**28. Нэр нь: MIGEON, J. - Sibérie ou Russie d'Asie.**

**Хэвлэгдсэн нь:** Парист, 1874 онд

**Хэмжээ нь:** 10.8 x 16.1 inch буюу 27.5 x 41.0 см.

Өнгөөр ялгасан.

Зургийг гангаар хүрээлэн чимсэн байна. Түүнийг J. Migeon *Géographie Universelle* цомогт хэвлүүлсэн байна.

Тийнхүү бид дээр 1590-1838 оны хооронд Баруун Европын орнуудад *Tartary, Tartaria, Tartaroum* нэрээр хэвлэгдсэн сонгомол 26, 1864, 1874 онд Лондон, Парист хэвлэгдсэн өнөөгийн ОХУ-ын Шивэрийн 2 зургийг өмнө дэлгэн харуулав. Дээрх газрын зургуудтай өнгөц танилцаад урьдчилан дараах дүгнэлтийг хийж болно. Үүнд:

- Уг газрын зургуудыг Эртний болон Дундад эртний үед Европын цөөнгүй оронд гарсан газрын зургын цомгуудад багтсан 200 гаруй зургаас Эртний болон



Дундад эртний Монгол гүрний түүх, соёлыг илүүтэй харуулсан талаас нь сонгож авсан тул тэр бүгдийг тухайлан нэгбүрчлэн судлавал зохих нэн ховор эх сурвалж баримтууд юм.

- Тэр бүгд нь зөвхөн Монголын түүх, соёл, газар нутгийн нэр судлал төдийгүй, бүс нутаг, түүний дотор юуны өмнө өнөөгийн ОХУ, Хятад, Солонгос, Япон улс судлалд маргашгүй чухал эх сурвалж болно.
- Тэдгээр нь хөрш орнуудын газар нутгийн маргаантай асуудлыг шийдвэрлэхэд ч ач тустай байж болно. Түүний нэг жишээ нь Күрилийн арлын асуудлыг шийдэхэд Италийн Венисед 1740 онд бүтээсэн, 10.8 x 13.3 inch буюу 27.5 x 33.8 см хэмжээ бүхий Дундад эртний Монгол гүрний ALBRIZZI, G. B. – Tartaria зураг юм.
- Тэдгээр нь түүх, соёлын эх сурвалж төдийгүй Европын олон оронд газрын зураг бүтээсэн өв түүх-урлагийн дурсгал мөн. Цөөнгүй зургийг нь зэс, ган зэргийг оролцуулан хээ хуар, бусад зураг зэргээр чимэглэсэн байна.
- Газрын биетийн нэр судлалын хувьд тэдгээр нь нэрийн хувьслыг тогтооход чухал сурвалж болно.



Дээрхийн нэгэн ижил Эртний болон Дунд эртний Төв Ази, Зүүн өмнөд Азийн орнууд, тухайлбал, Хятад, Япон, Солонгос зэрэг орнуудад хэвлэгдсэн эртний, дундад эртний газрын зургийн цомгуудыг анхааралтай судлан Монголын түүх-соёлтой холбоотой нэн даруй анхаарвал зохих зургуудыг сонгон түүвэрлэж болно. Тэр бүгдийг энэ удаа өмнөхийн ижил тоочин тодорхойлох зорилт тавьсангүй. Учир нь олон тохиолдолд дээрх орнуудад эртний ханзаар үйлдсэн, нөгөөтэйгүүр эх бүр нь интернэтэд хараахан ороогүй,

түүхэн дурсгал бичгүүддээ хадгалагдаж байгаа зэрэг учир шалтгаантай холбоотой. Гэвч тэдгээрээс судалгааны эргэлтэнд нэгэнт орсон нь ч цөөнгүй бий. Тухайлбал, бидний мэдэж байгаагаар, Тайван, Хон Хоны их сургуулиас эрхлэн гаргасан 2000 оноос хойш хэвлэгдсэн 2 томоохон цомогт Монголын түүх, соёлтой холбоотой цөөнгүй сурвалж оржээ.

Одоо Их Монгол гүрний хил хязгаар, нутаг дэвсгэрийг Солонгос, Хятадын дундад эртний газрын зурагт тод томруун харуулсан зарим зургаас нь жишээ болгон тоймлон өгүүлье.


Энэхүү газрын зургаас эзэн богд Чингисийн Хөх<sup>6</sup> гүрнийхээ хил хязгаарыг харж болохоор ажээ. Эл газрын зургийг одоогоос 700 жилийн өмнө газрын нэрийн дуудлага тэмдэглэсэн, газрын биетийг заасан хоёр зургийг 1402 онд Солонгост нэгтгэн ерийн зураг болгон бүтээсэн байна. Зураг хоёр хувиар бидний үед уламжилж ирсэн түүхийн нэн ховор дурсгал бөлгөө. Зураг дээр Хөх гүрний хил хязгаарыг тодорхой заажээ. Түүний төв хэсэгт Хятад байна. Солонгос, Япон, Перс, Төв Ази ч тод тусчээ. Харин Европын хэсэг Газрын Дундад тэнгисийг өнгөөр ялгаагүй тул тодруулахад төвөгтэй. Харин зургаас Францын Марсель, Севилья боомт хоёр хотын байршлыг зүүн талын хил заагаар нь тогтоож болохоор ажээ. Түүнчлэн зурагт Исламын хэсэг, Африкийн эрэг харагдаж байна. Энэхүү Хөх гүрний эртний зургийн тэмдэглэлээг англичилсан Жемс Флетчер (James Fletcher) эл зургийн

<sup>6</sup> Юань гүрний монгол нэрийн тухай судлаачдын санал нэлээн зөрүүтэй байна. Энэ тухай А. Пунцаг (Тэнгэрийн их Юань улсын түүхэн тэмдэглэл, УБ., 2010, 15-25 т.) бүтээлдээ өгүүлснээс үзнэ үү. Гэхдээ тэр бүрт “хөх” гэсэн ухагдахуун дагалдсан байна. Манай нэрт солонгосч Б. Сумьябаатар 2008 онд “Юань” нэрийг монголоор “ХӨХ” болохыг нотолсон байна. Тэрбээр: “<...>монголчуудын ихэд эрхэмлэдэг, “Хөх тэнгэр”, “Хөх монгол” гэдэгт ордог “Хөх” гэсэн утга 元 (нан. yuan)-д байна. Энэ нь ойр зуурын, бага, дунд гарын тольд үгүй. Хятад хэлний үгийн далай (辭海) хэмээх их толь (7-р утгыг үз.), “Хятад хэлний Их толь” (Тайванд хэвлэсэн, 21-р утгыг үз.), “Япон Хас толь” (21-р утгыг үз.)-нуудад байна. 元 (yuan) нь 元 (хөх, тэнгэр өнгө)-тэй ижил утгатай (辭海) гээд, Юаны үед тийн хэрэглэж байсан гэсэн тайлбартайгаа байна. (...)” гэжээ: (Acta Mongolica, 2008 (306), 28-р т.) Бид эл хувилбар саналаар их гүрнээ “Хөх” хэмээн энд нэрлэв.

түүхэн үлэмж ач холбогдлыг дүгнэхдээ: “These things are of great significance because they contradict the Eurocentric view that the world was discovered by Europeans. The map also shows that the Empire of the Mongols was the first international society in human history, a ‘borderless culture’.” “Тэр бүгд нь манай гарагийг европчууд нээсэн мэт үзэх Евротөв бүхий ойлголтыг няцаасанд үлэмж ач холбогдол нь оршино. Эл газрын зураг Монголын эзэнт их гүрнийг хүн төрөлхтний түүхэнд олон үндэстэн, ястныг нэгтгэсэн анхны нийгэм, “хил хязгааргүй соёл”-ыг бүтээснийг харуулжээ” гэжээ.

Тийнхүү монголчуудын бүтээсэн олон үндэстэн, ястны “анхны нийгэм”-д монгол хэл, төр засаг, цэрэг зэвсэг, улс үндэстний гэрээ, хэлэлцээр, элч, холбоо зэргийн үйлийг гүйцэлдүүлсэн улс, үндэстэн хоорондын албан ёсны харилцааны хэрэглэхүүн болж “хил хязгааргүй соёл”-ын нэгэн чухал талст болж байжээ.

Манай гарагийн тогтолцоо, ус хийгээд их газрын харьцаа, түүнийг зурагт тэмдэглэдэг багаж хэрэглэхүүний талаар монголчууд наад зах нь XIII зууны дунд үеэс мэдэж байсан тухай нангиадын түүхийн сурвалж бичиг, гол нь Хөх улсын судраас үүдэн Вальтер Фүкс (Walter Fuchs) 1946 онд Бээжингийн Католикийн их сургуулийн Дорно дахины судлалын цуврал бүтээлийн нэг “The Mongol Atlas” of China by Chu Ssu-pen and the Kuang-yu-T’u” –д анх дэлгэрэнгүй өгүүлж судлаачдын хүртээл болгожээ. Эл бүтээлдээ зохиогч 1320 онд Chu Ssu-pen-ний бүтээсэн газрын зургийн уламжлал Хятадад XIX зууны эцэс үе хүртэл үргэлжилсэн тухай өгүүлээд 1615 онд Kuang-yu-T’u-гийн бүтээсэн зургийг хамруулан нийт 10 гаруй зургийг судлан тайлбар хийсэн байна. Chu ssu-pen-ний зургийн онцлог нь тухайн үеийн нангиад төдийгүй Монгол хийгээд Төв, Зүүн Өмнөт Азийн, тухайлбал, Солонгосын зарим хэсэг зурагт туссан явдал юм. Монголын өнөөгийн газар нутгаас Хэрлэн, Орхон мөрний ай сав дахь газрын цөөнгүй нэр тэмдэглэгдсэн байна. Энэ бол монгол газар нутгийн нэрийн судлалд үнэт баримт мөн.



#### Хэрлэн мөрний ай сав газрын зураг

Уг зурагт тэмдэглэсэн Хэрлэн мөрний ай савын 66 нэрийг нанхидач эрдэмтэн Дугаржавын Нарангийн монголчилсноор бибээр “Монгол газар нутгийн нэрийн хэлбэр –утгазүйн судалгаа” (УБ., 2004) –ынхоо 20-24-р талд оруулсан болно. *Шигүү ой, Нарст хавцал, Нугаст гол, Цагаан гол, Урт Цагаан уул* зэрэг цөөнгүй нэрээс үзэхэд Хэрлэн мөрний ай сав битүү модтой байжээ гэхээр байна.




#### Орхон мөрний ай сав орчмын зураг

Орхоны мөрний ай сав газрын 20 нэрийг нанхидач эрдэмтэн Дугаржавын Нарангийн монголчилсноор бибээр “Монгол газар нутгийн нэрийн хэлбэр – утгазүйн судалгаа” (УБ., 2004) –ынхоо 25-р талд оруулсан болно. Нэрийн хэлхээнээс харахад олон нэрийг оноосон нэрээр нь бус тодорхойлох замаар тэмдэглэснийг нь бодвол зураг хийгээд нэрийг харь хүн үйлдсэн нь илэрхий байна. Нөгөөтэйгүүр, нэрийн тэмдэглээнээс харахад Орхон, Хэрлэн мөрний сав газар түүхэн хугацаанд үлэмж өөрчлөгджээ.

Энэ мэтээр дээр тоймлон тоочсон болон Төв, Зүүн өмнөт Азийн олон газрын зургийг нарийвчлан судлах нь хожмын биш, өнөөдрийн МГНН судлалын тулгамдсан асуудлын нэг болж байна.



Зураг 1



Зураг 2



Зураг 3



Зураг 4



Зураг 5



Зураг 6



Зураг 7



Зураг 8




Зураг 9




Зураг 10



Зураг 11



Зураг 12



Зураг 13




Зураг 14



Зураг 15




Зураг 16




Зураг 17




Зураг 18



Зураг 19



Зураг 20



Зураг 21



Зураг 22




Зураг 23




Зураг 24




Зураг 25



Зураг 26



Зураг 27



Зураг 28